



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 01 сарын 24-ны  
өдрийн 7089 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Эмгэг 648

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.1, 6.3.7, 6.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ыг энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар, “Мэргэжлийн холбоодод тавигдах шаардлагыг тодорхойлсон журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, аудитын үйлчилгээ үзүүлэхэд Хороонд бүртгүүлэх тухай журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120, 2021 оны 152 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГАД ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХ ОЛГОХОД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛСОН ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага (цаашид “зуучлалын байгууллага” гэх)-д зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Зуучлалын байгууллагууд нь Монгол Улсын Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.3.Зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зөвхөн хуулийн этгээд эрхэлнэ.

1.4.Зуучлалын байгууллага нь зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлнэ.

### **Хоёр.Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргагчид тавигдах нөхцөл шаардлага**

2.1.Зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 15,000,000.00 (арван таван сая) төгрөг байх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1.Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байх;

2.1.2.хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй, хууль ёсны орлого байх;

2.1.3.зуучлалын үйлчилгээний ерөнхий нөхцөл, хөлс, шагналын хэмжээг баталсан байх;

2.1.4.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай, агент, эсхүл борлуулалтын ажилтнуудыг мэргэшил, арга зүйгээр хангаж ажиллах, 1-ээс доошгүй брокертой байх;

2.1.5.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтантай байх;

2.1.6.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй 1-ээс доошгүй агент, эсхүл борлуулалтын ажилтантай байх;

2.1.7.брокер, агент, эсхүл борлуулалтын ажилтан нь "Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтэнд эрх олгох сургалт"-нд хамрагдаж, гэрчилгээ авсан байх;

2.1.8. үйл ажиллагаа эрхлэх ажлын байртай байх;

2.1.9.компанийн үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжтэй байх;

2.1.10.хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ёс зүйн дүрэмтэй байх;

2.1.11.зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан журамтай байх;

2.1.12.компанийн бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилээр боловсруулж, баталсан байх;

2.1.13.Хорооноос шаардсан бусад.

2.2.Энэ журмын нэгдүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, дөрөвдүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд Хороонд ирүүлнэ.

2.3.Гадаадын хөрөнгө оруулалттай үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь Хөрөнгө оруулалтын тухай хууль, энэ журмын 2.1-д заасан шаардлагаас гадна Хөрөнгө оруулах этгээдийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, үйл ажиллагааны талаар тухайн улсын холбогдох төрийн байгууллага болон банк, санхүүгийн байгууллагаас мэдээлэл, тодорхойлолт, лавлагаа авсан байна.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг нөхцөл шаардлага**

3.1.Зуучлалын байгууллагууд нь дараах нийтлэг нөхцөл шаардлагыг хангаж ажиллана.

3.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллах;

3.1.2.Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр биелүүлэх;

3.1.3.энэ журмын 4.1-д заасан нөхцөл шаардлагыг хангаж ажиллах;

3.1.4.Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж ажиллах;

3.1.5.Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

3.1.6.Компанийн дүрэм, журам, бизнес төлөвлөгөө, зуучлалын үйлчилгээний ерөнхий нөхцөл шаардлага, хөлс, шагналын хэмжээнд орсон өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэх.

3.2.Зуучлалын байгууллага нь Аудитын тухай хуулийн 10.1.1-т заасны дагуу санхүүгийн тайландаа аудит хийлгэж, дүгнэлтийг дараа оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ.

### **Дөрөв. Эрх бүхий албан тушаалтан, болон холбогдох ажилтнуудад тавигдах шаардлага**

4.1.Зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон холбогдох ажилтнууд нь Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шалгуур болон дараах нийтлэг шаардлагыг хангаж ажиллана:

4.1.1.насанд хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;

4.1.2.хэвийнээс бусад зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

4.1.3.Татварын албанд хувь хүний орлогын албан татварын тайланг тайлагнасан байх;

4.1.4.шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй байх;

4.1.5.Эрүүгийн хуульд заасан залилах, хөрөнгө завших болон эдийн засгийн эсрэг гэмт хэргүүдэд холбогдоогүй байх.

4.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

### **Тав. Салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл**

5.1.Зуучлалын байгууллага нь энэ журмын зургаадугаар хавсралтад дурдсан баримт бичгийн бүрдлийг ханган хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу салбар, төлөөлөгчийн газар байгуулах хүсэлт гаргах бөгөөд дараах шаардлагыг хангасан тохиолдолд Хороо албан бичгээр мэдэгдэж, гэрчилгээ олгоно:

5.1.1.үйл ажиллагаа эрхлэх нутаг дэвсгэрийн хязгаарлалтыг тодорхойлсон ажлын байр болон тоног төхөөрөмжтэй байх;

5.1.2.салбар, төлөөлөгчийн газрын удирдлага нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуур болон энэ журмын 4.1-д заасан шаардлагыг хангасан байх;

5.1.3.брокер нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуур болон энэ журмын 4.1-д заасан шаардлагыг хангасан байх;

5.1.4.салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

5.1.5."Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтэнд эрх олгох сургалт"-нд хамрагдаж, гэрчилгээ авсан ажилтантай байх.

5.2.Дээрх шалгуурыг хангаагүй тохиолдолд салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэхээс татгалзах бөгөөд энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

5.3.Салбар, төлөөлөгчийн газрыг дараах үндэслэлээр бүртгэлээс хасаж, гэрчилгээг хураан авч, нийгэд мэдээлнэ:

5.3.1.зуучлалын байгууллагын хүсэлтээр;

5.3.2.хууль тогтоомж, энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон;

5.3.3.салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй нь тогтоогдсон.

### **Зургаа. Холбогдох өөрчлөлт**

6.1.Зуучлалын байгууллага нь дараах өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг тухай бүр Хороонд урьдчилан мэдэгдэнэ:

6.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

6.1.2.оноосон нэрийн өөрчлөлт;

6.1.3.эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

6.1.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны өөрчлөлт;

6.1.5.Брокерын өөрчлөлт;

6.1.6.зуучлалын үйлчилгээний ерөнхий нөхцөл, хөлс, шагналын хэмжээний өөрчлөлт;

6.1.7.агент, эсхүл борлуулалтын ажилтны өөрчлөлт;

6.1.8.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон түүний салбар, төлөөлөгчийн газрын хаяг байршлын өөрчлөлт.

### **Долоо. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөд тавих шаардлага**

7.1.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд Компанийн тухай хуульд заасан хэлбэрээр өөрчлөлт оруулж болно.

7.2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахад дараах шаардлага тавигдана:

7.2.1. хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгө нь зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй, хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;

7.2.2. зуучлалын байгууллагын хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлого байх;

7.2.3. шинэ хувьцаа эзэмшигч нь энэ журмын 4.1-д заасан шаардлагыг хангасан байх.

7.3. Зуучлалын байгууллага нь энэ журмын тавдугаар хавсралтад дурдсан баримт бичгийн бүрдлийг ханган хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах өргөдөл гаргах бөгөөд дээрх шаардлагыг хангасан тохиолдолд Хороо албан бичгээр мэдэгдэнэ.

7.4. Зуучлалын байгууллагын хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч өөрчлөгдөх тухай бүр Хороонд мэдэгдэнэ.

### **Найм. Оноосон нэрийн өөрчлөлт**

8.1. Зуучлалын байгууллага нь энэ журмын долоодугаар хавсралтад дурдсан баримт бичгийн бүрдлийг ханган хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу оноосон нэрээ өөрчлөх хүсэлт гаргах бөгөөд энэ журмын 8.2-г заасан шаардлагыг хангасан тохиолдолд Хороо албан бичгээр мэдэгдэнэ.

8.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч оноосон нэрээ өөрчлөх нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байна.

8.3. Оноосон нэрийн өөрчлөлтийн тухай Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгож, баталгаажуулсны дараа Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

### **Ес. Бусад өөрчлөлт**

9.1. Зуучлалын байгууллага нь энэ журмын 6.1.3-6.1.8-д заасан өөрчлөлтүүдийг мэдэгдэхдээ хавсралтад дурдсан баримт бичгүүдийг Хороонд хэвлэмлээр болон цахимаар ирүүлэх бөгөөд холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд Хороо албан бичгээр мэдэгдэнэ.

9.2. Зуучлалын байгууллага энэ журмын 6.1-д заасан өөрчлөлтүүдийг шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд мэдэгдэнэ.

### **Арав. Хяналт, хариуцлага**

10.1. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---



Хэсэг 2.Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл						
Үүсгэн байгуулагч этгээдийг сонгоно уу.	Иргэн					
	Хуулийн этгээд					
Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг бөглөнө үү.						
Хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани					
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	Дотоодын хөрөнгө оруулалттай					
	Гадаадын хөрөнгө оруулалттай					
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл						
Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл	Овог, нэр					
	Регистрийн дугаар					
Оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө	₮					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим хуудасны мэдээлэл						
Цахим хаяг						
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?			Тийм		Үгүй	
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.						
Оноосон нэр						
Регистрийн дугаар						
Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани					
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдтэй ямар холбоотой болох (толгой, хараат, охин, зэргэлдээ... гэх мэт)						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Үйл ажиллагааны төрөл						
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Холбоо барих утасны дугаар						
Цахим хуудасны мэдээлэл						
Цахим хаяг						

Хувьцаа эзэмшигч нь иргэн бол дараах мэдээллийг бөглөнө үү.						
Овог, нэр						
Регистрийн дугаар						
Оршин суугаа хаяг						
Эрхэлж буй ажил албан тушаал						
Ажлын байрны хаяг						
Эзэмшсэн мэргэжил						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ						
Харилцах дансны үлдэгдэл						
Хадгаламжийн дансны үлдэгдэл						
<b>Хэсэг 3. Удирдлага болон боловсон хүчний талаарх мэдээлэл</b>						
ТУЗ-тэй эсэх	Тийм		Үгүй		Бүрэлдэхүүний тоо	
Хяналтын зөвлөлтэй байх эсэх	Тийм		Үгүй			
Дотоод хяналтын нэгжтэй эсэх	Тийм		Үгүй			
Нийт ажилтны тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүн						
Хяналтын зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн дарга						
Хяналтын зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн гишүүн						
Гүйцэтгэх захирал						
Нягтлан бодогч						
Брокер						
Агент, эсхүл борлуулалтын ажилтан						
Бусад						
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг албан тушаалтан бүрээр бичнэ үү.)</i>						
<b>Хэсэг 4. Үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны мэдээлэл</b>						
Худалдаж авсан						
Түрээсэлсэн						
Бусад						
<i>Тэмдэглэл: үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны хаяг байршил нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байхыг анхаарна уу!</i>						

<b>Хэсэг 5. Ашиглах техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл</b>					
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮

Зөвшөөрлийн тухай хууль, энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно уу.

Тусгай зөвшөөрөл авснаас хойш Зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

\_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтан

\_\_\_\_\_

гарын үсэг

\_\_\_\_\_

огноо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын хоёрдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХОЛБОГДОХ  
ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч зуучлалын байгууллагын оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Өөрчлөлтийн төрлийг сонгоно уу.						
	Салбар, төлөөлөгчийн газар нээх					
	Оноосон нэрээ өөрчлөх					
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах.					
<b>Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах</b>						
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах					
	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах					
А.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах						
Оноосон нэр/ Овог нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>						
Б.Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
Этгээд	Оноосон нэр	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)
<b>Хэсэг 2.Салбар, төлөөлөгчийн газар нээх</b>						
Салбар, төлөөлөгчийн байгуулах шийдвэрийн дугаар					Огноо	

Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны чиглэл						
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Салбар, төлөөлөгчийн газрын удирдах албан тушаалтны мэдээлэл						
Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
Салбар, төлөөлөгчийн газрын брокер, агент, эсхүл борлуулалтын ажилтны мэдээлэл						
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил
Брокер						
Агент, эсхүл борлуулалтын ажилтан						
Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны төлөвлөлт						
Үзүүлэлтүүд					Он	Он
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо						
Эх үүсвэрийн өртөг ₮						
Нийт орлого ₮						
Нийт зарлага ₮						
Хүлээгдэж буй ашиг ₮						
Өөрийн хөрөнгийн өгөөж ₮						
Активын өгөөж ₮						
Салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны мэдээлэл						
Худалдаж авсан						
Түрээсэлсэн						
Бусад						
Ашиглах техник төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл						
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮	
Программ хангамжийн нэр төрөл	Үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ ₮	

Хэсэг 3. Оноосон нэр өөрчлөх			
Хуучин нэр		Регистрийн дугаар	
Шинэчилсэн нэр			
Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан			

Холбогдох хууль тогтоомж болон энэ журамд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг мэдэгдэхэд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргасан:

\_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтан

\_\_\_\_\_

гарын үсэг

\_\_\_\_\_

огноо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын гуравдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ  
МЭДЭГДЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч зуучлалын байгууллагын оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Өөрчлөлтийн төрлийг сонгоно уу.						
	Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт					
	Брокерын өөрчлөлт					
	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны өөрчлөлт					
	Агент, эсхүл борлуулалтын ажилтны өөрчлөлт					
	Хаяг байршлын өөрчлөлт					
<b>Хэсэг 1. Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт</b>						
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	
<b>Хэсэг 2. Агент, эсхүл борлуулалтын ажилтны өөрчлөлт</b>						
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	
<b>Хэсэг 3. Хаяг байршлын өөрчлөлт</b>						
Өөрчлөлт оруулсан хаяг байршлын мэдээлэл	Өөрчлөлт орж буй нэгжийн нэр					
	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
Холбоо барих утас						

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, бүртгэж өгнө үү.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын дөрөвдүгээр хавсралт

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТЭД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГҮҮД

№		Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Зөвшөөрлийн хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"> <li>1. Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг</li> <li>2. Журмын нэгдүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл</li> <li>3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тухай төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ийн шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хурлын тэмдэглэл (нэг хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд хурлын тэмдэглэл шаардлагагүй)</li> </ol>	
2	Хуулийн этгээдийн бүртгэл	<ol style="list-style-type: none"> <li>1. Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл</li> <li>3. Улсын бүртгэлд бүртгүүлсэн компанийн дүрэм болон шинэчилсэн дүрмийн төсөл.</li> </ol> <p>Шинэчилсэн дүрмийн төсөлд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах нөхцөл</li> <li>2.хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх</li> <li>3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны эрх, үүрэг, хариуцлага</li> <li>4.Брокер, агент, эсхүл борлуулалтын ажилтны буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим</li> </ol>	
3	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж	<p>Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагаас олгосон гэрчилгээний хуулбараас гадна дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг</li> <li>2. Харьяалах улс, оронд татварын өртэй эсэх талаарх баримт бичиг</li> <li>3. Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг</li> </ol>	
4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл	<ol style="list-style-type: none"> <li>1. Тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг, гарал үүслийн талаарх тодорхойлолт</li> <li>2. Хувьцаа эзэмшигчдээс хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хуулийн этгээдийн жилийн эцсийн цэвэр ашиг эсхүл хуримтлагдсан ашгаас хуваарилсан ногдол ашиг байх тохиолдолд жилийн эцсийн аудитлагдсан</li> </ol>	

		<p>тайлан дүгнэлт, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан болон дэмжих бусад нотлох баримт бичиг</p> <p>3. Тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх дансны хуулга, банкны тодорхойлолт, бусад баталгаа</p>	
5	Баталж, хэрэгжүүлэх дүрэм журам	<p>Зуучлалын байгууллага нь дараах журмуудыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөнө. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөдөлмөрийн дотоод журам;</li> <li>2. Ажилтнуудын ёс зүйн журам;</li> <li>3. Зуучлалын үйл ажиллагааны журам;</li> <li>4. Зуучлалын үйлчилгээний ерөнхий нөхцөл, хөлс, шагналын хэмжээг тодорхойлсон журам</li> <li>5. Дээрх журмуудыг баталсан шийдвэр</li> </ol>	
6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	<ol style="list-style-type: none"> <li>1. Тус хуулийн 14.1-т заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, түүнийг баталсан шийдвэр</li> <li>2. Тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилсон тушаал, шийдвэр</li> <li>3. Энэ журмын 4.2-т заасан сургалтын гэрчилгээний хуулбар</li> <li>4. Тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li> <li>5. Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгын хуудас</li> <li>6. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li> </ol>	
7	Брокер	<ol style="list-style-type: none"> <li>1. Томилсон тушаал, шийдвэр</li> <li>2. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li> <li>3. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан болохыг нотлох баримт бичиг</li> <li>4. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li> <li>5. Энэ журмын 2.1.7-д заасан сургалтын гэрчилгээний хуулбар</li> <li>6. Эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ, ажлын байрны тодорхойлолт</li> <li>7. Хорооны цахим хуудсанд хувийн мэдээллийг байршуулахыг зөвшөөрсөн эсэх тухай албан бичиг</li> </ol>	
8	Агент, эсхүл борлуулалтын ажилтан	<ol style="list-style-type: none"> <li>1. Томилсон тушаал шийдвэр</li> <li>2. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li> <li>3. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li> <li>4. Эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээ</li> <li>5. Энэ журмын 2.1.7-д заасан сургалтын гэрчилгээний хуулбар</li> <li>6. Хорооны цахим хуудсанд хувийн мэдээллийг байршуулахыг зөвшөөрсөн эсэх тухай албан бичиг</li> </ol>	
9	Ажлын байр тоног төхөөрөмж	<ol style="list-style-type: none"> <li>1. Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсхүл, түрээсийн гэрээ</li> <li>2. Үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт</li> </ol>	
10	Бизнес төлөвлөгөө		

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын тавдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХҮСЭЛТЭД ХАВСАРГАХ  
БАРИМТ БИЧГҮҮД**

№		Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"> <li>1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай албан бичиг</li> <li>2. Энэ журмын хоёрдугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан өргөдөл</li> <li>3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хурлын тогтоол</li> <li>4. Нэг хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигчийн шийдвэр</li> <li>5. Холбогдох гэрээ хэлцэл болон нотлох баримт бичиг</li> <li>6. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан шинэчлэн боловсруулсан дүрмийн төсөл</li> </ol>	
2	Шинэ хувьцаа эзэмшигчийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл	<ol style="list-style-type: none"> <li>1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт</li> <li>2. Хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх дансны хуулга, банкны тодорхойлолт, бусад баталгаа</li> <li>3. Хувьцаа эзэмшигчдээс хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хуулийн этгээдийн жилийн эцсийн цэвэр ашиг эсхүл хуримтлагдсан ашгаас хуваарилсан ногдол ашиг байх тохиолдолд жилийн эцсийн аудитлагдсан тайлан дүгнэлт, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан болон дэмжих бусад нотлох баримт бичиг</li> </ol>	
3	Шинэ хувьцаа эзэмшигч	<ol style="list-style-type: none"> <li>1. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li> <li>2. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li> <li>3. Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгын хуудас</li> </ol>	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын зургаадугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР,  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ ХҮСЭЛТЭД  
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГҮҮД**

№		Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"> <li>1. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр, албан бичиг</li> <li>2. Энэ журмын хоёрдугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан салбар, төлөөлөгчийн газар байгуулахыг хүссэн өргөдөл</li> <li>3. Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ</li> <li>4. Нэмэлт өөрчлөлт оруулж, боловсруулсан шинэчилсэн дүрмийн төсөл</li> </ol>	
2	Салбарын, төлөөлөгчийн газрын удирдлага болон брокер	<ol style="list-style-type: none"> <li>1. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li> <li>2. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li> <li>3. Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгын хуудас</li> <li>4. Брокерын энэ журмын 2.1.7-д заасан гэрчилгээний хуулбар</li> <li>5. Брокерыг томилсон тушаал шийдвэр</li> <li>6. Брокерын Хорооны цахим хуудсанд хувийн мэдээллийг байршуулахыг зөвшөөрсөн эсэх тухай албан бичиг</li> </ol>	
3	Агент, эсхүл борлуулалтын ажилтан	<ol style="list-style-type: none"> <li>1. Томилсон тушаал шийдвэр</li> <li>2. Энэ журмын 2.1.7-д заасан гэрчилгээний хуулбар</li> <li>3. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li> <li>4. Хорооны цахим хуудсанд хувийн мэдээллийг байршуулахыг зөвшөөрсөн эсэх тухай албан бичиг</li> </ol>	
3	Судалгаа	Тухайн нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газар байгуулан ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаа	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын долоодугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
ОНООСОН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД  
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГҮҮД**

№		Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"><li>1. Оноосон нэрээ өөрчлөх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр, албан бичиг</li><li>2. Энэ журмын хоёрдугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан оноосон нэрээ өөрчлөхийг хүссэн өргөдөл</li><li>3. Оноосон нэрийн өөрчлөлтийг оруулсан компанийн шинэчилсэн дүрмийн төсөл</li><li>4. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь</li></ol>	
2	Улсын бүртгэл	Улсын бүртгэлийн байгууллагаас авсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын наймдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД  
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГҮҮД**

<b>№</b>		<b>Баримт бичгийн төрөл</b>	<b>Хуудасны тоо</b>
1	Хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"><li>1. Гүйцэтгэх захирал өөрчлөх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр, албан бичиг</li><li>2. Энэ журмын гуравдугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан өргөдөл</li><li>3. Томилсон тушаал</li><li>4. Эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний эх хувь</li></ol>	
2	Шинээр томилогдож буй гүйцэтгэх захирал	<ol style="list-style-type: none"><li>1. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li><li>2. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li><li>3. Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгын хуудас</li></ol>	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын есдүгээр хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН БРОКЕРЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГҮҮД**

№		Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"><li>1. Томилсон тушаал, шийдвэр болон албан бичиг</li><li>2. Энэ журмын гуравдугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан өргөдөл</li><li>3. Эрх бүхий албан тушаалтантай байгуулсан гэрээний хуулбар</li></ol>	
2	Шинээр томилогдож буй брокер	<ol style="list-style-type: none"><li>1. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li><li>2. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li><li>3. Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгын хуудас</li><li>4. Энэ журмын 2.1.7-д заасан гэрчилгээний хуулбар</li><li>5. Үл хөдлөх хөрөнгийн салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагыг нотлох баримт бичиг</li><li>6. Хувийн мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулахыг зөвшөөрөх эсэх талаарх албан бичиг</li></ol>	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын аравдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН АГЕНТ, ЭСХҮЛ  
БОРЛУУЛАЛТЫН АЖИЛТНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД ХАВСАРГАХ  
БАРИМТ БИЧГҮҮД**

№		Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Хүсэлт гаргах	<ol style="list-style-type: none"><li>1. Томилсон тушаал, шийдвэр болон албан бичиг</li><li>2. Энэ журмын гуравдугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан өргөдөл</li><li>3. Эрх бүхий албан тушаалтантай байгуулсан гэрээний хуулбар</li></ol>	
2	Шинээр томилогдож буй агент, эсхүл борлуулалтын ажилтан	<ol style="list-style-type: none"><li>1. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Монголын татварын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт)</li><li>2. Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт</li><li>3. Энэ журмын 2.1.7-д заасан гэрчилгээний хуулбар</li><li>4. Хувийн мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулахыг зөвшөөрөх эсэх талаарх албан бичиг</li></ol>	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын арван нэгдүгээр хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ БАЙРШЛЫН  
МЭДЭГДЭХЭД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГҮҮД**

<b>№</b>	<b>Баримт бичгийн төрөл</b>	<b>Хуудасны тоо</b>
1	Хаяг, байршлыг өөрчлөх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон албан бичиг	
2	Энэ журмын гуравдугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргасан өргөдөл	
3	Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ	
4	Хаяг, байршлын өөрчлөлттэй холбогдуулан боловсруулсан шинэчилсэн дүрмийн төсөл	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагад зөвшөөрөл, эрх олгоход тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон журам”-ын арван хоёрдугаар хавсралт

## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

### 1.Ерөнхий мэдээлэл

Ургийн овог	
Овог, нэр	
Регистрийн дугаар (иргэний бүртгэлийн дугаар)	
Иргэний харьяалал	
Эрхэлж буй ажил албан тушаал	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим шуудан	
Ажлын байрны хаяг	

Цээж зураг

### 2.Боловсрол (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ)

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

### 3.Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

4.ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан, брокер, агент, эсхүл борлуулалтын ажилтны холбогдох этгээдийн байдал:

Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Регистрийн дугаар (иргэний бүртгэлийн дугаар)	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

/...../

/Овог, нэр/

/...../

гарын үсэг/

/...../

огноо